



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 6/33

Дадал сум


**Б.Эрдэнэчимэгт ур чадварын
нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын Сургуулийн Өмнөх болон Ерөнхий Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйл, Боловсролын Ерөнхий хуулийн 33.3.3, Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цэцэрлэгийн (А байр) гал тогооны туслах ажилтан (Б.Эрдэнэчимэг) нь үндсэн ажлынхаа зэрэгцээ сумын “Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-нд байгууллагаас “Шугам бүжиг” төрөлд оролцсон 9 эмэгтэйчүүдэд монгол загварын хувцас оёсон тул бүтээлч ажлыг нь үнэлж ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. (Б.Эрдэнэчимэг)-т ур чадварын нэмэгдлийг 25 хувиар 5 дугаар сарын цалин дээр нэмэн тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Мөнхмаа)-д даалгасугай.

ЭРХЛЭГЧ



Н.ОДГАРАВ